

**Д. НАЦАГДОРЖ, Б. ЯВУУХУЛАН НАРЫН ШҮЛГИЙН
ТОЛГОЙ ХОЛБОЦЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Г. Галбаяр¹

Шүлэг найраг бичих гэдэг хэн дуртай хүний хийдэг ажил, хүсдэг хүсэл биш гэдгийг хүн төрөлхтөн эртнээс ухаарсан бөлгөө. Шүлэг бол туурвигч үндэстнийхээ оюун сэтгэлгээ, хэл, соёлын ерөнхий болон тусгай хууль зүй, бололцоо нөөцийн шигшигдсэн өв сангийн охь дээжист тулгуурласан сонсоход сонсголонтой, уншихад яруу, бодоход утга ундрахаар зөнч увдислаг уран сайхны дүрт сэтгэлгээ бүхий бүтэц тогтолцоо юм. Шүлэг уран сайхны дүрийг уянга, хөг эгшгийн хослолоор амилуулдгаараа үгийн яруу цуглуулга мэт харагдах ч утгаа бол гоо сайхныг мэдрэх, ертөнцийн юмс үзэгдлийг нээх урлаг. Утга ундарч, яруу уянга эгшиглэх шүлгийн энэ шинжид олон зүйл хамааралтай ч шүлгийн бүтэц тогтолцооны асуудал чухал байр суурь эзэлдэг. Нэн эрт үед үүсч, хөгжлийнхөө явцад дэлхийн бусад орны шүлэглэх урлагийн олон талын ололт амжилж, онцлогийг авч өөрийн уламжлалт сэтгэлгээ, шүлэглэх арга маягт идээшүүлэн төгөлдөршүүлж чадсаны хувьд монгол шүлгийн бүтэц тогтолцооны асуудал нэн өвөрмөц, олон талтай байдаг. Тийм ч учраас монгол шүлгийн бүтцийн онцлогийг судалсан зарим судлаачид *“Бидний мэдэж байгаа шүлэглэх аргын хэлбэрээс монголчуудын шүлэгт нэгийг ч гэсэн хамааруулах боломж алга. Монголын эртний уран зохиолын яруу найргийн дурсгалыг үзсэн ч, шинэ үеийн шүлгийн зохиолыг судлан үзсэн ч монгол шүлэгт ямар нэгэн шүлгийн ёс журмыг хэрэглэх ямар ч боломжгүй байна”*² хэмээн гайхан эргэлзжээ. Энэ утгаараа олон үеийн гадаад, дотоодын олон судлаач шинжээчдийн судалгааны арга барил, хүч хөдөлмөр, авьяас билгийг шаардах нь дамжиггүй. Бид энэ удаад монгол шүлгийн бүтэц дэх олон янзын холбоцын зөвхөн толгой холбоц буюу мөрийн тэргүүн үеийн холбоцын онцлогийг орчин үеийн монголын уран зохиолын гол төлөөлөгчид болох Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлэг найргаар жишээлэн тодруулж, хоёр найрагчийн шүлгийн холбоцуудыг хооронд нь харьцуулан үзэж тус бүрийнх нь урлах арга маягийн онцлогийг гаргахын зэрэгцээ монгол шүлгийн толгой холбоц шүлгийн уран сайханд хэрхэн хамааралтайг авч үзэхийг хичээв. Энэ бяцхан судалгаанд Дашдоржийн Нацагдоржийн Улаанбаатар хотод 1996 онд хэвлэгдсэн “Бүрэн түүвэр” (Удиртгал бичиж, редакторлосон Д. Цэдэв)-т орсон 113 шүлэг найраглал, Бэгзийн Явуухулангийн Улаанбаатар хотод 1985 онд хэвлэгдсэн “Түүвэр зохиол” (Эмхтгэсэн Ж. Адъяа, Я. Баатар, Редактор Д. Цэнд)-д орсон 301 шүлэг найргийг хамруулан авч үзсэн болно.

¹ Hankuk University of Foreign Studies

² Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып 1. Спб., 1880. стр-321

Шүлгийн толгой холбоцыг олон улсад “аллитераци” гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Зарим газар грек хэлний “анафора” буюу “толгой ижил” гэсэн утга бүхий үгээр томъёолон өгүүлсэн нь бий. “Аллитераци” хэмээх үг нь латин хэлний *ad+littera* буюу “ойролцоо үсэг, нөхөр үсэг” гэсэн утгатай үг. Бидний санавал аллитераци гэсэн үгтэй монгол шүлгийн толгой холбоцыг яг дүйлгэн ойлгох аргагүй. Учир нь өрнө дахины эртний шүлэгт байсан мөрийн эхний холбоцыг заах энэ үгний утгаас монгол шүлгийн толгой холбоц бол нэлээд өөр буюу монгол үндэстний аж амьдрал, сэтгэлгээний олон зуун жилийн онцлог буюу аливаа зүйлийн эхлэлийг “гараа сайн бол бариа сайн” гэх мэтээр онцгой анхаарч сайнаар эхлүүлдэг ёс уламжлалтай нарийн сэжмээр холбоотой ойлголт юм. Өрнөдийн яруу найргийн онол, нэр томъёог дагнан судалсан эрдэмтэн Л. Квятковский “Яруу найргийн толь” бүтээлдээ “Аллитерация шүлгийн эртний хувилбар Европ, Азийн зарим үндэстний (герман, швед, казак, киргиз, буриад болон бусад) яруу найрагт байдаг”³ хэмээн бичсэн байна. Мөн шүлэг судлаач, онолч эрдэмтэн В. Жирмүнский “Шүлгийн онол” хэмээх бүтээлдээ “Эртний германы аллитераци шүлэг” гэсэн тусгай бүлэг оруулаад энэ тооллын 700-1100 оны хооронд англосаксон, эртний исланд, эртний саксон, эртний германы толгой холбоцын шүлэг нь аажимдаа шүлгийн адаг холбоц буюу сүүл холбоцод ууссан түүхтэйг дурдсан байна⁴. Тэрбээр мөн германы баатарлаг туульс ихэвчлэн аллитераци хэлбэртэй байсан онцлогтойг өгүүлээд цааш нь “Энд хос томъёо гэж нэрлэгдсэн хоёр ойр төрлийн ойлголт ерөнхий нэг холбоосоор зангилагдаж хэл зүйн зэргэд үүсгэдэг”⁵ хэмээн онцлон өгүүлсэн байна. Эртний монголчуудын өвөг болох Хүннүчүүдийн өрнө дахин руу хийсэн аян дайн, эзэлж авсан газраа тодорхой хэсэг нь суурьшсан онцлогтой холбоотойгоор монгол шүлгийн толгой холбох ёс ямар нэгэн хэмжээгээр эртний аари үндэстэн, фин-угорын бүлгийн улсууд, скандинавын орнуудын шүлэг найрагт нөлөөлсөн бололтой. Энэ асуудлыг тусад нь авч үзэхийг зорьж байгаа тул энэ удаа дэлгэрэнгүй өгүүлэлгүй орхив.

Шүлгийн бүтэц тогтолцоог тодруулах нэг чухал зүйл нь олон янзын холбоц юм. Өөрөөр хэлбэл шүлэгт тухайн хэлний авианы ижилсэл, эсрэгцэл зэрэг олон боломж нөөцийг ашиглан шүлгийн мөрүүдийг тодорхой хэсгүүдэд нь холбон зангидаж, нэгээс нөгөө нь ургаж, нэгдээ нөгөө нь захирагдаж тодорхой эрэмбэ үүсгэсэн тогтолцоо бий болгосон гэсэн үг.

1.Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн тоог нийтэд нь харьцуулан үзэх нь

	Д. Нацагдорж	Б. Явуухулан
1.Нийт шүлгийн тоо	113	301
2.1. Нийт хос уянгаас бүрдсэн шүлгийн тоо	21	13
2.2 Хос уянгын нийт бадгийн тоо	155 буюу 310 мөр шүлэг	69 буюу 138 мөр шүлэг
3.1. Нийт 4 мөрт шүлгийн тоо	67	222
3.2. 4 мөрт шүлгийн нийт бадгийн тоо	506 буюу 2024 мөр шүлэг	1640 буюу 6560 мөр шүлэг

³ Квятковский А. Поэтический словарь. М., 1983. срт-46

⁴ Жирмүнский В. Теория стиха. Л., 1975. стр-380

⁵ Жирмүнский В. Теория стиха. Л., 1975. стр-381

4. Янз бүрээр бадагласан ба бадаглаагүй задгай шүлгийн тоо	24 буюу 520 мөр шүлэг	66 буюу 1584 мөр шүлэг
--	-----------------------	------------------------

Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн тоог нийтэд нь харьцуулан үзэхэд Д. Нацагдорж Б. Явуухуланг бодвол харьцангуй цөөн шүлэг бичсэн байна. Энэ нь нэгд, цөөн жил уран бүтээл туурвисантай нь холбоотой, хоёрт, Б. Явуухулан зөвхөн яруу найраг дагнан бичиж байсан бол Д. Нацагдорж уран зохиолын үндсэн гурван төрлөөр жигд бичиж байснаас үүдэлтэй биз. ХХ зууны монгол яруу найргийн хөгжлийн өвөрмөц хоёр үеийн гол төлөөлөгчид болох Д. Нацагдорж, Б. Явуухулан нар бусад яруу найрагчтай харьцуулахад цөөн хэдэн жинтэй бүтээл бичиж, цагийг эзэлснээрээ онцлог байна.

2. Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн толгой холбоцыг шүлгийн толгой холбоцын үндсэн хэсгүүдийн дагуу харьцуулан үзье.

2.1. Хос уянгын толгой холбоц

		Д. Нацагдорж	Б. Явуухулан
1	1 авиагаар холбосон бүрэн холбоц	95 бадаг	31 бадаг
2	2 авиагаар холбосон бүрэн холбоц	41 бадаг	27 бадаг
3	3 ба түүнээс дээш авиагаар холбосон бүрэн холбоц	1 бадаг	2 бадаг

Жишээ:

		Д. Нацагдорж	Б. Явуухулан
1	1 авиагаар холбосон бүрэн холбоц	<i>Өндөр хангай халзан уулын бэл дээр Өвгөн тарвага шагшран шагшран сууна /“Нэгэн дусал цуснаа таван сая”/</i>	<i>Айлын галыг хүүхэн ноцооно Азтай найртай амьдрал эхэлнэ /“Нэргүй шүлэг”/</i>
2	2 авиагаар холбосон бүрэн холбоц	<i>Хүн төрөлхтний дотор Хүүхнүүдийг гүйцэх үзэсгэлэнгүй /“Анчны дуу”/</i>	<i>Хавирган сар шөнийн тэнгэрт уран чимэгтэй Ханилсан над миний хонгор гоо үзэсгэлэнтэй /“Бодол”/</i>
3	3 ба түүнээс дээш авиагаар холбосон бүрэн холбоц	<i>Хувьсгалт орны түмэн шат алхан хөгжсөнийг Хувь хувьдаа зөвлөцөн баясгаланг эдэлнэ /“Эрүүлийг хамгаалах газар”/</i>	<i>Залуу навчсыг салхи үлээн хөглөж Залгаж хэлэх үгийг байгаль хүртэл хүлээж байна /“Нэргүй шүлэг”/</i>

Эндээс үзвэл өгүүлэн буй хоёр найрагч хос уянга буюу хоёр мөрт шүлгийг нийт шүлэгтэй нь харьцуулахад тийм ч олон бичсэнгүй. Гэхдээ хос уянгат шүлгийн толгой холбоцыг нийт шүлгийн толгой холбоцтой харьцуулахад илт давамгайл байна. Түүгээр ч барахгүй хос уянгын шүлгийн толгой холбоцыг харьцангуй шүлгийн чөлөөт хууль зүйд тулгуурлан лавшруулж холбосон онцлогтой байна. Гэтэл дөрвөн мөрт, найман мөрт шүлгүүдэд нь, мөн задгай цагаан шүлгийн дунд хос уянгын шинжтэй шүлгүүд, толгой

холбоцод захирагдсан хэсгүүд нэлээд түгээмэл харагдаж байна. Энэ бүхэн нь Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын бүтээлд, эртний аман зохиолын шүлэг найргаас угшилтай нэг зүйлийг нөгөөтэй нь зүйрлэн сэтгэх сэтгэлгээнд тулгуурласан хос уянгын ерөнхий загвар түгээмэл байгааг, тэр загвар нь цаашаа өрөгдөн дөрвөн мөр, найман мөрийг үүсгэсэн онцлог маш түгээмэл байна.

2.2. 4 мөрт шүлгийн толгой холбоц

		Д. Нацагдорж	Б. Явуухулан
1	Бүрэн холбоц	109 бадаг (Үүнээс 24 бадаг нь хоёр авиагаар, 6 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)	457 бадаг (Үүнээс 116 орчим бадаг нь хоёр авиагаар, 23 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)
2	Хос холбоц	50 бадаг (Үүнээс 20 орчим бадаг нь хоёр авиагаар, 5 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)	198 бадаг (Үүнээс 83 орчим бадаг нь хоёр авиагаар, 16 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)
3	Салаавчилсан холбоц	4 бадаг (Бүгд 1 авиагаар толгой холбогдсон байна)	36 бадаг (Үүнээс 7 бадаг нь хоёр авиагаар, 3 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)
4	Бөгжилсөн холбоц	4 бадаг (Бүгд 1 авиагаар толгой холбогдсон байна)	48 бадаг (Үүнээс 9 бадаг нь хоёр авиагаар, 5 бадаг 3 ба түүнээс дээш авиагаар толгой холбогдсон байна)

Жишээ:

		Д. Нацагдорж	Б. Явуухулан
1	Бүрэн холбоц	<i>Алагланхан харагданаа хө хө Алим жимстэй уул байнаа хө хө Амраг хоёр үртэйгээ хө хө Амьдарч болмоор уул байнаа хө хө /“Цэнхэрлэн харагдах”/</i>	<i>Мод модны дундаас эгцхэн ургадаг Мөнх ногоон агар Мянга түмний дундаас сайхан харагддаг Миний хайрт ээжий /“Энх амгалан ээжий”/</i>
2	Хос холбоц	<i>Элдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд Эрт эдүгээг бодогдуулан нуугдсан сэтгэлийг сэргээнэ Өнөр сайхан төл баян хотыг чимэхэд Өлгийтэй бяцхан хүүхэд эцэг эхээ баясгана /“Дөрвөн цаг”/</i>	<i>Дурлал гэдэг амны хий биш Дуртай болгон зайдалдаг хонины морь биш Хорвоод хүн ганцхан л удаа төрдөг юм Хосгүй амрагаа гэж нэг л хүнийг шилдэг юм /“Нэргүй шүлэг”/</i>
3	Салаавчилсан холбоц	<i>Хар малгайтай залуу эхнэрийн Үзэсгэлэнг би ихэд магтана</i>	<i>Нарны илч шиг төөнөөд ирэхдээ</i>

		<i>Халзан толгойтой түүний нөхрийн Аргыг би бас сайшаана /“Гайхалтай”/</i>	<i>дурлал Гантиг ханыг ч бол нэвтлээд орно Нүүдлийн шувуу шиг буцаад явахдаа дурлал Ган аргамжаас ч бол мултраад арилна /“Нэргүй шүлэг”/</i>
4	Бөгжилсөн холбоц	<i>Шалиг үгсийг ярилцаж Санаа сэтгэлийг хуурна Сайхан хүүхнийг ярьж Шөнийн зүүдийг хүлээнэ /“Уйтгар зовлонг санагдуулахуй”/</i>	<i>Сарны доорх уудам хорвоод Сайхан хүн хичнээн ч олон юм бэ? Сайхны дундаас сайхан чи минь Сарны доорх миний сар юм! /“Сайхан чамдаа”/</i>

Энэ бүхнээс дүгнэж үзвэл Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн толгой холбоцыг тус бүрийнх нь нийт шүлгийн тоотой харьцуулан үзэхэд харьцангуй ойролцоо хувьтай байна. Монгол шүлгийн толгой холбоцын үндсэн арга маяг болох бүрэн холбоц, хос холбоц, салаавчилсан холбоц, бөгжилсөн холбоцуудыг өгүүлэх дэс дарааллын дагуу ашигласан байна. Өөрөөр хэлбэл хамгийн түгээмэл тохиолдолд бүрэн холбоцыг, хамгийн цөөн тохиолдолд бөгжилсөн холбоцыг ашиглажээ. Энэ нь шүлгийн толгой холбоцыг олон янзаар хийж болох ч толгой холбоцын үндсэн гол онцлог нь ижил авиа, ижил үе, ижил үгийг ижилсүүлэн нэгээс нөгөө нь дуудагдах, сонсогдох аргаараа ундарч байх, эргүүлээд бие биенээ захирч байх тогтолцоотойг харуул байна. Нийт шүлгийн тоотой харьцуулж үзвэл Б. Явуухулан Д. Нацагдоржоос илүүтэй шүлгийн толгой холбоцонд анхаарч, тэр дундаа бөгжилсөн, салаавчилсан зэрэг холбоцуудыг арай түлхүү /10 орчим хувиар илүү/ ашиглаж байсан нь харагдана.

Д. Нацагдорж, Б. Явуухулан нар шүлгийн толгой холбоцыг ихээхэн чухалчилан үзэж байсан нь тодорхой байна. Энэ нь угтаа бол монгол шүлгийн бүтцийн нэг гол онцлог нь толгой холбоц мөн болохыг баталгаажуулж байгаа хэрэг. Ер нь монгол шүлгийг судалсан судлаачид ихэнх нь “монгол шүлгийн гол онцлог толгой холбоц” хэмээн үзсэн нь үндэслэлтэй зүйл болох нь тодорхой аж. Тухайлбал, XIX зууны нэрт яруу найрагч, онолч В. Гүнначуг “Иргэн үсэг дор-фин (-тэгш), шан (-өгсөх), чүй (-долгио), лүе (-уруу) буй хэмээхэд монгол үсэг дор мөн эр эм саармаг үсгийн ялгал буй болой. Иргэн дор шүлэг аялгуу байхад монголд мөн ч аялгуу буй. Адилтгаваас аль үсгээр тэргүүнийг эхэлсэн бол төгсгөлд тэр үсгээр эхэлбээс даруй нийлэлцэх болой. Хэрэв “А” толгойгоор эхэлбээс “Ариун ..., Агуулан ..., Амттай ..., Архи ..., ” хэмээх мэтээр даруй аялгууны шүлэг болох болой”⁶ хэмээсэн бол түүний дүү В. Инжаннаши “Улс улсын зан суртлын аяг дагаж улс улсын бичиг судар ч их аяс зан санаа нь өөр өөр. Үлгэрлэвэл ертөнцийн уур амьсгал туйлын сайхан өнгөт нь цэцэг атал цэцэг бүр адилгүй өөр өөртөө нэг зүйлийн сайхан өнгө буй. Бас ертөнцийн уур амьсгалын туйлын амттайхан амт нь жимс бөгөөд жимс бүр адилгүй тус тусдаа нэгэн зүйлийн амттайхан амт бус уу. Үзтэл иргэн үсг сүүл даран хэлж монгол үг толгой холбон өгүүлэх ба төвд үсэг түргэн дөтийг эрхэмлэж, манж үсэг тус тааруулан зохиожээ”⁷ хэмээн өгүүлсэн байна. Тэгвэл гадаадын эрдэмтдээс Оросын монголч эрдэмтэн А. Руднеев “монгол шүлгийн үндсэн гол шинж нь толгой холбоц болно”⁸, Чехийн монголч эрдэмтэн П.

⁶ Гулранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. Хөх хот., 1959. 32 дугаар тал

⁷ Инжаннаши В. Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959. 57-58 дугаар тал

⁸ Руднеев А. Образцы монгольской народной словесности. СПб., 1880. стр. 328

Поуха “Монгол шүлгийн гадаад гол шинж нь гэвэл толгой холбож ая нийлүүлэх явдал юм. Ийм шинж монгол шүлэглэлд эрт дээр үеэс тодорчээ. Толгой холбоц зонхилсон “Монголын нууц товчоо”-ны шүлэглэсэн зарим хэсгийг үзвэл толгой холбоц нь зөвхөн шүлгийн мөрийн эхэнд чухам ямар авиа байгаагаас шалтгаалаад зогсохгүй харин шүлгийн эхний нэгдүгээр үеэнд ямар авианы нийлбэр байгаагаас голчлон шалтгаалж байна”⁹ гэх зэргээр өгүүлсэн нь цөөнгүй. Манай өөрийн шүлэг судалсан судлаач эрдэмтэд ч энэ саналыг ихэнх нь дэмжсэн байна. Жишээ нь, С. Буяннэмэх “Холбоо найруулга гэж толгой холбосноос нэрлэжээ. Энэ нь А бол А, Э бол Э толгой үсгийг олж мөрүүдийн дээд тэргүүнийг нь тохируулах бөгөөд тийнхүү тохируулахдаа шүлгийн адил заавал дөрөв дөрвөөр толгой холбож нэг нэгэн бадгаар бичих ёстой юм. Хичнээн толгой, хичнээн мөр боловч хязгаарлагдахгүй ба бадаг хэмээн холбоо найруулгат зориуд ялгаварлах явдалгүй ажгуу”¹⁰, Н. Жамбалсүрэн “Монгол шүлгийн толгой холбох нь европ шүлгийн сүүл холбоотой адилхан юм. Толгой холбохдоо ойролцоо дуудлагатай үгээр холбож болно. Толгой холбохдоо баялаг үгтэйгээр чадамгай холбож хэрэглэвэл шүлгийг сайхан болгоно”¹¹, Д. Цэнд “Шүлгийн байгуулалтыг тодотгох элдэв холбоцоос монгол шүлэгт толгой холбоц маш их үүргийг гүйцэтгэдэг”¹², Л. Түдэв “Монгол шүлэг гэж хармагц эсвэл сонсмогц таних тэмдэг нь “толгой холбоц” юм”¹³ гэх зэргээр дүгнэсэн нь санамсаргүй зүйл бус бодит баримтад тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлтүүд ажээ.

Толгой холбоцонд эгшигт холбоо, гийгүүлэгч холбоо гэсэн үндсэн хоёр янз байна. Холбоцын гол онцлог нь өгүүлэх амьсгалыг тааруулдаг, нэг мөрөөс дараагийн мөр урган гарах дуудлага ижил, ойролцоо байх үндэс болдог. Энэ нь монгол шүлгийн толгой холбоц шүлгийн бүтцийн онцлогийг харуулаад зогсохгүй дотоод мөн чанар дахь айзам хэмнэлийг үүсгэн сонсголонтой, аялгуутай болгоход чухал үүрэгтэйг харуулж байна. Тиймд монгол шүлгээс хүний сэтгэлийг татах уянгалаг торгон хөг аяс ямагт ундарч байдаг.

Д. Нацагдорж шүлэг найрагтаа гийгүүлэгч холбоцыг түлхүү ашиглаж байснаараа холбоцоор дамжуулж утгыг чухалчилж байсан тал харагдаж байна. Харин Б. Явуухулан эгшигт холбоцыг түлхүү ажиглаж байсан нь тодорхой байна. Энэ нь Б. Явуухулангийн шүлэг яруу сонсголонт шинжтэйн нууцыг хадгалж байгаа хэрэг.

Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлэгт үгийн толгойг нарийвчлан холбож шүлэглэснээс гадна эр эм эгшгийг төрлөөр нь ялгаж холбон, үлгэрлэвэл ү, э хоёрыг үгүй бол о, у хоёрыг холбох жишээтэй нь их байна. Тийм ч учраас судлаачид “Д. Нацагдорж ойролцоо авиагаар ихээхэн холбон шүлэглэдэг байжээ. Ингэх нь түүний шүлгийн урлагт ер саад болсонгүй. Тэрээр “Янаг” гэдэг шүлэгтээ:

... Үнэн сэтгэл гэгч

Энэ ертөнцөд ховор юм

Учирч түүнийг олох нь

⁹ Поуха П. “Монголын нууц товчоо”-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб., 1968

¹⁰ Буяннэмэх С. Утга зохиолын үүд. (Гар бичмэл эх) 1936. 111-112 дугаар тал

¹¹ Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин. №8 1966.

¹² Цэнд Д. Монгол шүлгийн тогтолцооны асуудалд. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979. 161 дүгээр тал

¹³ Түдэв Лодонгийн Шүлэглэсэн туульс. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002. 389 дүгээр тал

Орчлон дээр чухаг юм гэж үнэн, энэ гэсэн хоёр үгийг учирч, орчлон гэсэн хоёр үгийг нэгэн адил авч холбон шүлэглэжээ. Ингээд үзэхэд ойр авиа үгээр холбон шүлэглээд зогсохгүй бас:

... Уг сэтгэл нэг бол

Үг хэл найрамдуу

Янаг амраг гэгч нь

Эмзэг гэгч аргагүй гэх мэтээр ойролцоо дуудлагатай бүрэн үгээр холбон шүлэглэхэд бас болдог ажээ.”¹⁴ хэмээн онцлон өгүүлсэн байна. Ийм онцлог Б. Явуухулангийн шүлэгт ч түгээмэл байна. Энэ мэтээр *м, б, зэрэг* уруулын гийгүүлэгчүүдийг ижилсүүлэх юмуу, эсвэл *с, ш, зэрэг* сонсголт гийгүүлэгчүүдийн сонсголт шинжээр холбоц хийсэн, дан эгшгээр юмуу гийгүүлэгчээр ижилсүүлэн холбоц хийсэн зэрэг олон онцлогууд өгүүлэн буй хоёр найрагчийн шүлэгт давхар давхар ажиглагдаж байна. Энэ бүхэн нь Д. Нацагдорж, Б. Явуухулан нар шүлгийн холбон найруулах эрдэмд хосгүй авьяастай байсныг нөгөө талаар монгол хэлний баялаг шинж, монгол шүлгийн холбоцын нөөц боломжийг давхар давхар харуулж байна.

Монгол аман зохиол, бичгийн яруу найргаас харахад толгой холбоц, дунд холбоц, сүүл холбоц нэн түгээмэл уламжлалтай нь илт. Өөрөөр хэлбэл монгол шүлгийн бүтцийн нэгэн онцлогийг харуулах энэ холбоцууд түүхэн урт удаан хугацаанд нарийсан боловсорсоор ирсэн нь Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгээс харагдаж байна. Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлэгт шүлгийн толгой холбоцоос гадна дунд холбоц, сүүл холбоц түгээмэл харагдаж байгааг толгой холбоцтой нь харьцуулан үзэх нь бас чухал зүйл юм.

Энэ бүхэн өгүүлэн буй хоёр найрагчийн холбон найруулах их авьяас, монгол хэлний баялаг шинжийг харуулах төдийгүй монгол шүлгийн бүтэц тогтолцооны нэгэн өвөрмөц хэсэг нь холбоцууд, тэр дундаа толгой холбоц байдаг гэдгийг нотлож байна.

НОМ ЗҮЙ

1. Байгалсайхан С. Уран зохиол шинжлэлийн удиртгал. Уб., 1995
2. Буяннэмэх С. Утга зохиолын үүд. (Гар бичмэл эх) 1936
3. Гаадамба Ш. Утга зохиолын онолын товч. Уб., 1957
4. Галбаатар Д. Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио., 2002
5. Галбаяр Г. Уран зохиол шинжлэлийн лекц. Уб., 2002
6. Герасимович Л. К. Монгольское стихосложение. Л., 1975
7. Гүлранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. Хөх хот., 1959
8. Дамдинсүрэн Ц. Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай өгүүлэл. “Шинэ толь” сэтгүүл. Уб., 1938. №2 (14)
9. Дамдинсүрэн Ц. Олег цэцэний орчуулгын тайлбар. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
10. Дулам С., Хасбаатар Ц. Утга зохиолын үүд. Уб., 1980
11. Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин. №8 1966
12. Жирмунский В. Теория стиха. Л., 1975
13. Инжаннаши В. Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959

¹⁴ Содном Б. Д. Нацагдоржийн уран зохиолын тухай. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб., 1962. 64-65 дугаар тал

14. Квятковский А. Поэтический словарь. М., 1983
15. Нацагдорж Дашдоржийн Бүрэн зохиол. Уб., 1996
16. Отгонсүрэн Д. Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог. Уб., 1984
17. Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып 1. Спб., 1880
18. Поуха П. “Монголын нууц товчоо”-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб., 1968
19. Ринчен Б. Монгол шүлгийн учир. “Хэл зохиол” цуврал бичиг. Уб., 1969
20. Руднеев А. Образцы монгольской народной словесности. СПб., 1880
21. Содном Б. Д. Нацагдоржийн уран зохиолын тухай. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб., 1962
22. Содном Балданы Монгол шүлгийн арга маяг. Зохиол судлал. Уб., 2008-2009
23. Туденов Г. Бурятской стихосложение. Улан Уде., 1958
24. Түдэв Лодонгийн Шүлэглэсэн туульс. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
25. Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал, монгол яруу найраг. Уб., 1989
26. Цэдэв Д. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. Уб., 1974
27. Цэнд Д. Монгол шүлгийн тогтолцооны асуудалд. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979
28. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал. Уб., 1977
29. Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. “Үгийн ил шид” эмхэтгэл. Уб., 1968
30. Явуухулан Бэгзийн Түүвэр зохиол. Уб., 1985

SUMMARY

A poem is a structural system, which is melodious to listen to, harmonious to read, and full of meaning and artistic character. It is based upon a nation's intellectual thinking, language, general and specific cultural concepts, and the essence of the respective heritage. As a poem resuscitates artistic character with a combination of euphoria and tune it creates the melodic combination of words. But in fact, the true art is to feel the beauty and discover the phenomena of the world. The structure of Mongolian poems has extraordinary features and versatility. Since they arose in ancient times, they have borrowed many of the progressive aspects of foreign poetry and improved on them in accordance with the traditional mindset and stylistic preferences of our country. Therefore its study requires a lot of effort, talent, and research methods from many foreign and domestic researchers. Currently we focus on the study of only the anaphora or rhyme of the first syllable of the line in comparison to the many other kinds of rhymes in Mongolian poems. In the example of the poems provided by two main representatives of Mongolian literature, D.Natsagdorj and B.Yavuukhulan. They compared the anaphora of the two poets, identified the main features of their creative style and determined how anaphora is connected to the artistry of the poem.

As a result of this investigation, it is clear that the common rhymes of poems by D.Natsagdorj and B.Yavuukhulan is anaphoric. This shows that the investigations conducted by the researchers, who believed that the most characteristic feature of Mongolian poetry is anaphora, based on verifiable facts and scientific evidence.

D.Natsagdorj commonly used consonant rhymes, proving that he viewed them as important to the content of his poems though rhymes. B.Yavuukhulan frequently used vowel rhymes, showing his secret for melodic and harmonious poems.